

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/21

Өлгий

**Ажлын хэсэг
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/578, 2022 оны А/436 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах, “Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд хэрэгжүүлэх зорилгоор тус тус ТУШААХ нь:

1. Монгол Улсын анхан шатны эрүүл мэндийн байгууллага (ЭМБ)-аас үзүүлж буй тусламж, үйлчилгээ, санхүүжилтийн талаарх мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй хүргэх, тусламж, үйлчилгээний талаар иргэдийн сэтгэл ханамж, санал хүсэлтийг хүлээн авах, сэтгэл ханамжийн байдалд дүн шинжилгээ хийж, үр дүнг иргэд болон шийдвэр гаргагчдад мэдээлэх, хариу арга хэмжээ авахад туслах цахим системийн хөгжүүлэлтийг хэрэгжүүлэх, хянах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Назимгүл - МЭХ-ний БӨ аймгийн салбарын тэргүүн

Нарийн бичгийн дарга: О.Айбота -ЭМГ-ын эдийн засагч

Гишүүд:

Е.Сауле – Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

М.Адилбиш - “Танд тус дэм больё” ТББ –ын тэргүүн


К.Нурбек - Өрхийн эрүүл мэндийн төвийн ня-бо

Ж.Нурбота-Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

М.Халайых - Мэдээллийн технологи телемедицин хариуцсан ажилтан

2. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний ил тод байдлыг хангах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх цахим порталыг хэрэгжүүлэх, Өрхийн эрүүл мэндийн төвийн цахим мэдээлэлд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Хяналт-шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга /Ш.Иманхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.САКЕН